ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗРЫН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

**АУДИТЫН КОД: СНАГ-2025/07/НА-СТА-ТТЗ**

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.


**Монгол Улсын ерөнхий аудиторын орлогч: Я.Самбууням**
Утас: 51-261665 Цахим хаяг: sambuunyamya@audit.gov.mn
**Санхүү, Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг**
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
**Аудитын менежер: Э.Энхбаатар**
Утас: 261885 Цахим хаяг: enkhbaatare@audit.gov.mn
**Ахлах аудитор: Г.Мөнхчимэг**
Утас: 261740 Цахим хаяг: munkhchimegg@audit.gov.mn
**Аудитор: Ч.Мөнхбулган**
Утас: 261740 Цахим хаяг: munkhbulganch@audit.gov.mn

**АГУУЛГА**


1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН....3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ....6
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан....6
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан....6
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан....7
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан....8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан....9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан....11
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА....13
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа....13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин....13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал....14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд....14
3.4.1 Мөнгөн хөрөнгө....14
3.4.2 Авлага....15
3.4.3 Бараа материал....15
3.4.4 Үндсэн хөрөнгө....16
3.4.5 Өр төлбөр....16
3.4.6 Засгийн газрын хувь оролцоо....16
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв....17
3.5.1 Төсвийн төлөвлөлт....17
3.5.2 Төсвийн гүйцэтгэл....17
3.5.3 Нэмэлт төсөв....18
3.6 Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл....18
4. АУДИТЫН ТАЙЛАН....19
4.1 Ерөнхий зүйл....19
4.2 Материаллаг байдал....19
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт....19
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал....19
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт....19
4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн....20
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал....20
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ....21
5.1 Албан шаардлага....21
6. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ....23

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| БНХАУ | Бүгд Найрамдах Хятад Ард Улс |
| БОАЖС | Байгаль орчин, аялал жуулчлалын сайд |
| БОАЖЯ | Байгаль орчин, аялал жуулчлалын яам |
| БОХЗТЛ | Байгаль орчин хэмжил зүйн төв лаборатори |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар |
| ТТЗ | Төсвийн төвлөрүүлэн захирагч |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| ХХОАТ | Хувь хүний орлогын албан татвар |
| ХШҮДАГ | Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар |
| УЦУОШТ | Ус, цаг уур, орчны шинжилгээний төв |
| УЦУОСМХ | Ус, цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| ЦУОШГ | Цаг уур, орчны шинжилгээний газар |

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА Э.БАТТУЛГА ТАНАА

2025.03.25 № 01/1206
танай ____________-ны №____________-т

Хязгаарлалттай санал дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Цаг уур, орчны шинжилгээний газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан аудитын хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Цаг уур, орчны шинжилгээний газрын харьяа 26 нэгжийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар залруулагдаагүй 1,341.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч бидний тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д *"төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх"*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д *"Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах"*, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.6-д *"дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх"*, 16.5.7-д *"байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах"* гэж заасантай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

## Асуудлыг онцолсон хэсэг

Цаг уурын улсын сүлжээний чадавхыг бэхжүүлэх ажлын хүрээнд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2024 оны А/37 дугаар тушаалаар 2,500.0 сая төгрөгийг шийдвэрлүүлж Цаг уурын автомат станц 25 ширхгийг худалдан авч суурилуулснаар улсын сүлжээний 137 өртөө 100 хувь автомат станцаар хэмжилт хийх нөхцөл бүрдсэн, Ус судлалын автомат хэмжих хэрэгсэл, түвшин хэмжигч 17 иж бүрдэл болон бусад ус судлалын хэмжих хэрэгсэл, сэлбэг материалыг худалдан авч ашигласнаар Туул гол болон томоохон голуудын савд ажиглагдах үерийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, мэдээллийн шуурхай байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

## Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд улсын сүлжээний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор байгууллагын урсгал зардлаас Цаг уурын сүлжээнд 380.0 сая төгрөг, аэрологийн шинжилгээнд 640.0 сая төгрөг, Ус судлалын сүлжээнд 326.0 сая төгрөг, орчны шинжилгээнд 170.0 сая төгрөгөөр шаардлагатай хэмжих хэрэгсэл, сэлбэг материал, урвалж бодис худалдан авч үйл ажиллагаандаа ашигласан байна.

## Бусад мэдээлэл

Цаг уур, орчны шинжилгээний газар нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг хуулийн цаглабарт хугацаандаа ирүүлж, Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх заалтыг хэрэгжүүлж аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг саадгүй гаргаж ирүүлсэн.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

## Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ Я.САМБУУНЯМ

# 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

*/мянган төгрөг/*

| Код | Тайлангийн үзүүлэлт | 2023 оны 12-р сарын 31 | 2024 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| 1 | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **10,317,601.6** | **14,614,239.0** |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 347,457.3 | 473,218.5 |
| 33 | АВЛАГА | 1,248,135.8 | 1,412,703.6 |
| 34 | УРЬДЧИЛГАА | 2,736.0 | - |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 8,719,272.5 | 12,728,316.9 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 38,257,803.1 | 47,451,353.0 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 38,257,803.1 | 47,451,353.0 |
| 39200 | Биет хөрөнгө | 28,888,369.9 | 37,180,133.8 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 9,369,433.2 | 10,271,219.2 |
| 3 | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **48,575,404.7** | **62,065,592.0** |
| 4 | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **215,846.0** | **62,764.2** |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 215,846.0 | 62,764.2 |
| 41300 | Өглөг | 215,846.0 | 62,764.2 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 48,359,558.7 | 62,002,827.8 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 48,359,558.7 | 62,002,827.8 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 26,012,280.0 | 26,787,837.4 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 18,010,916.3 | 30,866,810.0 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 4,336,362.4 | 4,348,180.4 |
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **48,575,404.7** | **62,065,592.0** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

*/мянган төгрөг/*

| Код | Тайлангийн үзүүлэлт | 2023 оны 12-р сарын 31 | 2024 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| I | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **61,201,149.8** | **95,575,344.7** |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 8,970,676.8 | 13,732,585.2 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 8,970,676.8 | 13,732,585.2 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 52,230,473.0 | 81,842,759.5 |
| II | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **56,930,319.4** | **82,708,560.8** |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 56,930,319.4 | 82,708,560.8 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 54,249,477.4 | 78,842,950.2 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 36,912,149.4 | 59,891,009.2 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 4,526,031.6 | 7,588,216.5 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 1,348,632.7 | 1,338,674.7 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 1,329,211.4 | 896,242.1 |
| 2105 | Норматив зардал | 103,381.6 | 89,511.0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 3,001,603.1 | 731,392.3 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 196,385.0 | 326,551.4 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,129,277.8 | 1,571,478.8 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,702,804.8 | 6,409,874.2 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 2,680,842.0 | 3,865,610.6 |
| III | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **4,270,830.4** | **12,866,783.9** |
| V | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **144,812.8** | **(4,218.6)** |
| VI | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **4,126,017.6** | **12,871,002.5** |

## 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*/мянган төгрөг/*

| № | Тайлангийн үзүүлэлт | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Цөөнхийн хувь оролцоо | Нийт цэвэр хөрөнгө өмч |
|---|---|---|---|---|
| **1** | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **43,888,914.1** | **-** | **43,888,914.1** |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 59,874.0 | - | 59,874.0 |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 43,948,788.1 | - | 43,948,788.1 |
| 4 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | (34,178.0) | - | (34,178.0) |
| 5 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | 318,931.0 | - | 318,931.0 |
| 6 | Тайлант үеийн үр дүн | 4,126,017.6 | - | 4,126,017.6 |
| **7** | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **48,359,558.7** | **-** | **48,359,558.7** |
| 8 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 760,448.6 | - | 760,448.6 |
| 9 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 49,120,007.3 | - | 49,120,007.3 |
| 10 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 9,932.0 | - | 9,932.0 |
| 11 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | 1,886.0 | - | 1,886.0 |
| 12 | Тайлант үеийн үр дүн | 12,871,002.5 | - | 12,871,002.5 |
| **13** | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **62,002,827.8** | **-** | **62,002,827.8** |



ТОРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөг/

| Код | Тайлангийн үзүүлэлт | 2023 оны 12-р сарын 31 | 2024 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **52,610,838.1** | **82,918,882.3** |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 312,763.1 | 648,579.9 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 312,763.1 | 648,579.9 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 52,298,075.0 | 82,270,302.4 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **51,333,510.9** | **79,243,773.4** |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 51,333,510.9 | 79,243,773.4 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 48,219,584.1 | 74,807,583.6 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 36,875,496.9 | 60,000,334.0 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 4,609,399.5 | 7,550,691.6 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 1,356,503.1 | 1,345,064.8 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 677,430.5 | 697,055.7 |
| 2105 | Норматив зардал | 101,849.2 | 74,750.7 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 3,084,831.4 | 2,406,660.6 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 203,755.7 | 325,264.3 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,139,820.7 | 2,268,133.6 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 170,497.1 | 139,628.3 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 3,113,926.8 | 4,436,189.8 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **1,277,327.2** | **3,675,108.9** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **1,123,357.4** | **3,549,347.7** |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 1,123,357.4 | 3,549,347.7 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 1,123,357.4 | 3,549,347.7 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **(1,123,357.4)** | **(3,549,347.7)** |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | **153,969.8** | **125,761.2** |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 193,487.5 | 347,457.3 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 347,457.3 | 473,218.5 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **77,207,247,100.00** | **75,901,118,088.81** | **1,306,129,011.19** | **98.3** |
| **УРСГАЛ ЗАРДАЛ** | **77,207,247,100.00** | **75,901,118,088.81** | **1,306,129,011.19** | **98.3** |
| **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **75,759,884,600.00** | **74,615,901,614.53** | **1,143,982,985.47** | **98.5** |
| **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **58,904,242,100.00** | **58,335,383,583.00** | **568,858,517.00** | **99.0** |
| Үндсэн цалин | 29,847,302,200.00 | 29,677,303,577.51 | 169,998,622.49 | 99.4 |
| Нэмэгдэл | 18,055,422,200.00 | 17,767,133,878.13 | 288,288,321.87 | 98.4 |
| Унаа хоолны хөнгөлөлт | 7,218,235,300.00 | 7,151,372,865.21 | 66,862,434.79 | 99.1 |
| Урамшуулал | 3,783,282,400.00 | 3,739,573,262.15 | 43,709,137.85 | 98.8 |
| **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **7,487,907,600.00** | **7,342,835,496.42** | **145,072,103.58** | **98.1** |
| Тэтгэврийн даатгал | 5,128,711,300.00 | 5,046,549,117.38 | 82,162,182.62 | 98.4 |
| Тэтгэмжийн даатгал | 589,698,800.00 | 581,195,250.98 | 8,503,549.02 | 98.6 |
| ҮОМШӨ-ний даатгал | 295,248,700.00 | 291,990,293.65 | 3,258,406.35 | 98.9 |
| Ажилгүйдлийн даатгал | 294,850,300.00 | 280,352,469.04 | 14,497,830.96 | 95.1 |
| Эрүүл мэндийн даатгал | 1,179,398,500.00 | 1,142,748,365.37 | 36,650,134.63 | 96.9 |
| **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **1,366,364,200.00** | **1,329,124,888.49** | **37,239,311.51** | **97.3** |
| Гэрэл, цахилгаан | 616,311,800.00 | 598,947,261.03 | 17,364,538.97 | 97.2 |
| Түлш, халаалт | 668,330,200.00 | 657,292,452.35 | 11,037,747.65 | 98.3 |
| Цэвэр, бохир ус | 73,403,300.00 | 64,646,902.61 | 8,756,397.39 | 88.1 |
| Байрны түрээс | 8,318,900.00 | 8,238,272.50 | 80,627.50 | 99.0 |
| **Хангамж, бараа материалын зардал** | **411,663,100.00** | **407,168,951.23** | **4,494,148.77** | **98.9** |
| Бичиг хэрэг | 46,722,300.00 | 46,623,149.00 | 99,151.00 | 99.8 |
| Тээвэр, шатахуун | 197,737,000.00 | 197,583,858.79 | 153,141.21 | 99.9 |
| Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 91,828,000.00 | 87,936,044.44 | 3,891,955.56 | 95.8 |
| Ном, хэвлэл | 10,156,000.00 | 10,156,000.00 | - | 100.0 |
| Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 4,531,000.00 | 4,225,600.00 | 305,400.00 | 93.3 |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 60,688,800.00 | 60,644,299.00 | 44,501.00 | 99.9 |
| **Нормативт зардал** | **51,745,100.00** | **51,536,090.00** | **209,010.00** | **99.6** |
| Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 32,315,900.00 | 32,312,670.00 | 3,230.00 | 100.0 |
| Хоол, хүнс | 890,400.00 | 890,400.00 | - | 100.0 |
| Нормын хувцас, зөөлөн эдлэл | 18,538,800.00 | 18,333,020.00 | 205,780.00 | 98.9 |
| **Эд хогшил, урсгал засварын зардал** | **5,288,888,200.00** | **5,001,847,805.28** | **287,040,394.72** | **94.6** |
| Багаж, техник, хэрэгсэл | 4,815,212,300.00 | 4,529,435,393.28 | 285,776,906.72 | 94.1 |
| Тавилга | 12,000,000.00 | 12,000,000.00 | - | 100.0 |
| Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 16,142,000.00 | 15,328,100.00 | 813,900.00 | 95.0 |
| Урсгал засвар | 445,533,900.00 | 445,084,312.00 | 449,588.00 | 99.9 |
| **Томилолт, зочны зардал** | **156,425,100.00** | **151,286,090.00** | **5,139,010.00** | **96.7** |
| Дотоод албан томилолт | 156,425,100.00 | 151,286,090.00 | 5,139,010.00 | 96.7 |
| **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **2,037,287,900.00** | **1,941,990,335.31** | **95,297,564.69** | **95.3** |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,697,122,900.00 | 1,606,728,780.25 | 90,394,119.75 | 94.7 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 12,006,700.00 | 10,971,800.00 | 1,034,900.00 | 91.4 |
| Даатгалын үйлчилгээ | 18,439,400.00 | 18,142,590.16 | 296,809.84 | 98.4 |
| Тээврийн хэрэгслийн татвар | 4,643,100.00 | 4,321,952.90 | 321,147.10 | 93.1 |
| Тээврийн хэрэгслийн оношлогоо | 1,354,800.00 | 1,132,200.00 | 222,600.00 | 83.6 |
| Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 225,469,200.00 | 224,617,000.00 | 852,200.00 | 99.6 |
| Газрын төлбөр | 39,383,300.00 | 37,246,858.00 | 2,136,442.00 | 94.6 |
| Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 554,900.00 | 554,900.00 | - | 100.0 |
| Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 38,313,600.00 | 38,274,254.00 | 39,346.00 | 99.9 |
| **Бараа үйлчилгээний бусад зардал** | **55,361,300.00** | **54,728,374.80** | **632,925.20** | **98.9** |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 4,786,500.00 | 4,784,821.80 | 1,678.20 | 100.0 |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 50,574,800.00 | 49,943,553.00 | 631,247.00 | 98.8 |
| **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **1,447,362,500.00** | **1,285,216,474.28** | **162,146,025.72** | **88.8** |
| **Бусад урсгал шилжүүлэг** | **1,447,362,500.00** | **1,285,216,474.28** | **162,146,025.72** | **88.8** |
| Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 3,000,000.00 | 3,000,000.00 | - | 100.0 |
| Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 1,434,242,300.00 | 1,272,195,360.28 | 162,046,939.72 | 88.7 |
| Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 10,120,200.00 | 10,021,114.00 | 99,086.00 | 99.0 |
| **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **77,207,247,100.00** | **75,901,118,088.81** | **1,306,129,011.19** | **98.3** |
| **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **77,113,907,700.00** | **75,661,610,162.15** | **1,452,297,537.85** | **98.1** |
| Улсын төсвөөс санхүүжих | 77,113,907,700.00 | 75,661,610,162.15 | 1,452,297,537.85 | 98.1 |
| **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **93,339,400.00** | **239,507,926.66** | **(146,168,526.66)** | **256.6** |
| Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 62,691,400.00 | 152,545,428.00 | (89,854,028.00) | 243.3 |
| Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 30,648,000.00 | 86,962,498.66 | (56,314,498.66) | 283.7 |
| **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | **3812** | **3736** | **76.00** | **98.0** |
| **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **26** | **26** | **-** | **100.0** |
| Төсвийн байгууллага | 26 | 26 | - | 100.0 |
| **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | **1893** | **1855** | **38** | **98.0** |
| Удирдах ажилтан | 63 | 38 | 25 | 60.3 |
| Гүйцэтгэх ажилтан | 1745 | 1723 | 22 | 98.7 |
| Үйлчлэх ажилтан | 85 | 90 | (5) | 105.9 |
| Гэрээт ажилтан | - | 4 | (4) | |
| **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **1893** | **1855** | **38** | **98.0** |
| Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 29 | 32 | (3) | 110.3 |
| Төрийн тусгай албан хаагч (ТТ) | - | 119 | (119) | |
| ШУ-ны салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮШУ) | 89 | 34 | 55 | 38.2 |
| Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 1775 | 1670 | 105 | 94.1 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | | **5,242,307,018.44** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **5,242,307,018.44** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | **3,527,350,114.62** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | | **1,664,950,428.35** |
| 210101 | Үндсэн цалин | | 118,694,765.71 |
| 210102 | Нэмэгдэл | | 1,317,759,079.64 |
| 210104 | Урамшуулал | | 228,496,583.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | | **207,856,111.42** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | | 179,535,545.31 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | | 6,775,516.66 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | | 5,727,336.44 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | | 1,944,072.70 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | | 13,873,640.31 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | | **15,939,930.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | | 8,266,978.00 |
| 210302 | Түлш, халаалт | | 4,062,952.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | | 3,610,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | | **276,263,767.78** |
| 210401 | Бичиг хэрэг | | 55,456,133.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | | 120,543,673.45 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | | 20,078,837.33 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | 80,185,124.00 |
| **2105** | **Нормативт зардал** | | **23,214,570.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | | 12,449,570.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | | 10,765,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | | **503,876,898.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | 225,634,900.00 |
| 210602 | Тавилга | | 64,081,820.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | | 13,091,890.00 |
| 210604 | Урсгал засвар | | 201,068,288.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | | **173,978,221.00** |
| 210701 | Гадаад албан томилолт | | 32,295,581.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | | 141,682,640.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | | **605,935,953.07** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 596,867,682.07 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | | 1,316,600.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | | 894,450.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | | 357,572.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | | 240,500.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | | 219,400.00 |
| 210807 | Газрын төлбөр | | 6,039,749.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | | **55,334,235.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 25,583,235.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | 29,751,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | | **1,714,956,903.82** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | | **1,133,190,187.97** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | | 733,265,476.97 |
| 213206 | Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт | | 328,000.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | | 7,280,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 392,316,711.00 |



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

| | | | |
|---|---|---|---|
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | | **581,766,715.85** |
| 213305 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт,нэмэлт санхүүжил төвлөрүүлэх шилжүүлэг | | 581,766,715.85 |
| **I** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | | **5,242,307,018.44** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | **5,242,307,018.44** |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | | 1,714,338,064.38 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 1,476,102,280.50 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 1,164,441,792.55 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 887,424,881.01 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Цаг уур, орчны шинжилгээний газар нь эрхэм зорилгоо "Ус, цаг агаар, байгаль орчны төлөв байдалд байнгын хяналт шинжилгээ хийж, бодит болон урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллээр нийгмийн хэрэгцээг шуурхай хангах, байгалийн болзошгүй гамшгийн эрсдэлээс сэрэмжлүүлэхэд оршино" гэж тодорхойлсон байна.

Агентлагийн стратегийн зорилт тус бүрийн хүрээнд дараах үйл ажиллагааны гол зорилтыг хэрэгжүүлнэ:

- Богино, дунд, урт хугацааны урьдчилсан мэдээ, цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлийн сэрэмжлүүлэх мэдээллийг гаргаж, хэрэглэгчдийг шуурхай үйлчлэх;
- Цаг уур, орчны шинжилгээний улсын сүлжээг мэргэжил, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах, сүлжээний техник, технологийн шинэчлэл, өргөтгөл төлөвлөж, хэрэгжүүлэх, дотоодын болон олон улсын мэдээ солилцооны хэвийн ажиллагаа, хэмжлийн технологи, стандартын нэгдмэл байдлыг хангах, цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаа, уур амьсгалын мэдээ, мэдээлэл, зөвлөмжөөр үйлчлэх ажлыг зохион байгуулах;
- Цаг уур, орчны шинжилгээний салбарыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах, үйл ажиллагааны менежментийг боловсронгуй болгох, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, салбарын үйл ажиллагаанд дотоод хяналт тавих, шалгалт зохион байгуулах, цаг уур, орчны шинжилгээний салбарын санхүү, хөрөнгө оруулалтыг төлөвлөж хэрэгжүүлэх, хангамж, аж ахуйн үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах, төсвийн санхүүжилтийг үр ашигтай зарцуулах;
- Хүрээлэн буй орчны чанарын төлөв байдлыг үнэлэх, мэргэжлийн дүгнэлт гаргах, орчны хяналт шинжилгээний үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах, хэмжил зүй, стандартын нэгдмэл байдлыг хангах, агаарын чанарын мэргэжлийн албаны үүргийг гүйцэтгэх;
- Ус, цаг уур, орчны мэдээллийн төрийн архивыг эрхлэх, уур амьсгал, ус, цаг уур, орчны мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, мэдээний бүрэн бүтэн, нээлттэй байдал, хадгалалт хамгаалалтыг зохион байгуулах, хэрэглэгчдийг цахим болон цаасан суурьтай мэдээллээр үйлчлэх.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Ус, цаг уур, орчны шинжилгээний салбарт өнөөгийн байдлаар Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай, Агаарын тухай, Байгалийн ургамлын тухай, Гамшгаас хамгаалах тухай, Усны тухай зэрэг гол хуулиудаас гадна салбарын хамаарал бүхий 12 хууль, УИХ-ын болон Засгийн газрын тогтоолоор баталсан 9 үндэсний хөтөлбөр, 11 үзэл баримтлал, үндсэн чиглэл, төлөвлөгөөг баталсан байна.

Тайлант хугацаанд төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль;
- Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- Төрийн албаны тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Хөдөлмөрийн тухай хууль шинэчилсэн найруулга;
- Бусад холбогдох хууль, дүрэм журам.

Удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил хэрэгжүүлэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.



01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цаг уур, орчны шинжилгээний газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил, гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус агентлаг нь 2024 онд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон өөрчлөлтүүдийг оруулж, шинэчилсэн байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Цаг уур, орчны шинжилгээний газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 13,490.2 сая төгрөгөөр буюу 21.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, үндсэн хөрөнгө, өр төлбөр, хөрөнгө өмчийн данснуудад материаллаг өөрчлөлт гарсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлтүүд* */мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт/+/, Бууралт/-/ |
|---|---|---|---|
| Мөнгөн хөрөнгө | 347,457.3 | 473,218.5 | 125,761.2 |
| Авлага | 1,248,135.8 | 1,412,703.6 | 164,567.8 |
| Урьдчилгаа | 2,736.0 | - | (2,736.0) |
| Бараа материал | 8,719,272.5 | 12,728,316.9 | 4,009,044.4 |
| Үндсэн хөрөнгө | 38,257,803.1 | 47,451,353.0 | 9,193,549.9 |
| **НИЙТ ХӨРӨНГӨ** | **48,575,404.7** | **62,065,592.0** | **13,490,187.3** |
| Өглөг | 215,846.0 | 62,764.2 | (153,081.8) |
| Засгийн газрын хувь оролцоо | 48,359,558.7 | 62,002,827.8 | 13,643,269.1 |
| **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **48,575,404.7** | **62,065,592.0** | **13,490,187.3** |

*Эх сурвалж: Цаг уур, орчны шинжилгээний газар 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс нилээд бүхий өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 125.8 сая төгрөг, авлага дансны үлдэгдэл 164.6 сая төгрөг, бараа материал дансны үлдэгдэл 4,009.0 сая төгрөг, үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 9,193.5 сая төгрөг, Засгийн газрын хувь оролцоо 13,643.2 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, өглөг дансны үлдэгдэл 153.1 сая төгрөгөөр буурсан байна.

#### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 473.2 сая төгрөг болж, 125.8 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл* */ мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт/+/, Бууралт/-/ |
|---|---|---|---|
| Төрийн сангийн харилцах | 347,457.3 | 473,218.5 | 125,761.2 |
| **Дүн** | **347,457.3** | **473,218.5** | **125,761.2** |

*Эх сурвалж: Цаг уур, орчны шинжилгээний газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэлд тус газар болон харьяа байгууллагуудын ахмадын сангийн 473.2 сая төгрөг Төрийн сангийн харилцах дансанд байршиж байна.

*Аудитын илрүүлэлт:*

- Төсөв захирагч өөртөө шийдвэр гаргаж 3.5 сая төгрөгийн нэмэгдэл цалин авсан. */Өмнөговь аймгийн УЦУОШТ/;*
- Ахмадын сангийн дансанд тайлант оны эцэст төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл 7.6 сая төгрөгийг төвлөрүүлсэн. */Архангай аймгийн УЦУОШТ/;*
- Цаг агаарын мэдээний тодорхойлолтыг үнэлэн, тайлант онд орсон 2.4 сая төгрөгийн орлогыг байгууллагын дансанд төвлөрүүлээгүй, ТББ-ын дансанд төвлөрүүлж, зориулалт бусаар зарцуулсан */Булган аймгийн УЦУОШТ/.*

### 3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 1,412.7 сая төгрөг болж, 164.6 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №2. Авлагын үлдэгдэл* */мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Ажиллагсадтай холбогдсон авлага | 1,815.7 | 10,465.0 | 8,649.3 |
| Татаас санхүүжилтийн авлага | 433,142.9 | 569,749.0 | 136,606.1 |
| Байгууллагаас авах авлага | 794,068.4 | 815,991.7 | 21,923.3 |
| Хувь хүмүүсээс авах авлага | 19,108.8 | 16,497.9 | (2,610.9) |
| **Дүн** | **1,248,135.8** | **1,412,703.6** | **164,567.8** |

*Эх сурвалж: Цаг уур, орчны шинжилгээний газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Авлагын үлдэгдэл нэмэгдэхэд ЦУОШГ-ын БНХАУ-аас цаг агаарт зориудаар нөлөөлөх сум пуужин худалдан авах 793.4 сая төгрөг, УЦУОСМХ-ийн татаас санхүүжилтийн 569.7 сая төгрөгийн авлага нь голлон нөлөөлсөн байна.

### 3.4.3 Бараа материал

Бараа материал дансны үлдэгдэл 12,728.3 сая төгрөг болж, өмнөх оноос 4,009.0 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл* */мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| **Түүхий эд материал** | **6,416,774.8** | **9,337,969.1** | **2,921,194.3** |
| Тусгай зориулалтын материал | 6,355,306.6 | 9,308,697.2 | 2,953,390.6 |
| Эм боох материал | 36,862.1 | 6,125.8 | (30,736.3) |
| Бэлэн бүтээгдэхүүн | 3,400.0 | 1,940.0 | (1,460.0) |
| Дуусаагүй үйлдвэрлэл | 21,206.1 | 21,206.1 | - |
| **Хангамжийн материал** | **2,302,497.7** | **3,390,347.8** | **1,087,850.1** |
| Бичиг хэргийн материал | 104,835.9 | 158,090.7 | 53,254.8 |
| Аж ахуйн материал | 470,433.6 | 910,621.7 | 440,188.1 |
| Сэлбэг хэрэгсэл | 876,899.0 | 1,161,376.5 | 284,477.5 |
| Түлш, шатах тослох материал | 42,348.1 | 83,033.9 | 40,685.8 |
| Барилгын засварын материал | 63,210.5 | 84,302.5 | 21,092.0 |
| Бусад хангамжийн материал | 689,299.8 | 949,212.5 | 259,912.7 |
| **Мал амьтан** | 55,470.8 | 43,710.0 | (11,760.8) |
| **Дүн** | **8,719,272.5** | **12,728,316.9** | **4,009,044.4** |

*Эх сурвалж: Цаг уур, орчны шинжилгээний газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 3,897.9 сая төгрөгийн бараа материал, бусдаас үнэ төлбөргүй авсан 5,442,053.7 сая төгрөгийн бараа материалаар нэмэгдэж, тайлант онд 3,015,383.6 сая төгрөгийн бараа материалыг зарцуулж, 5,548,734.4 сая төгрөгийн бараа материалыг харьяа байгууллагуудад шилжүүлсэн байна.



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

### 3.4.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 47,451.3 сая төгрөг болж, өмнөх оноос 9,193.5 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл* /мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| **Биет хөрөнгө** | **28,888,370.0** | **37,006,122.0** | **8,117,752.0** |
| Барилга, байгууламж, орон сууц | 16,531,547.4 | 20,137,562.5 | 3,606,015.1 |
| Авто-тээврийн хэрэгсэл | 1,980,209.6 | 1,645,953.2 | (334,256.4) |
| Машин, тоног төхөөрөмж (компьютер) | 9,692,778.2 | 14,623,129.7 | 4,930,351.5 |
| Тавилга, аж ахуйн эд хогшил | 486,564.4 | 588,872.1 | 102,307.7 |
| Бусад үндсэн хөрөнгө | 193,866.8 | 7,201.0 | (186,665.8) |
| Ном | 3,403.6 | 3,403.5 | (0.1) |
| **Биет бус хөрөнгө** | **9,369,433.2** | **10,104,324.4** | **734,891.2** |
| Программ хангамж | 246,805.0 | 204,951.1 | (41,853.9) |
| Бусад биет бус хөрөнгө | 9,122,628.2 | 9,899,373.3 | 776,745.1 |
| **Дүн** | **38,257,803.2** | **47,451,353.0** | **9,193,549.8** |

*Эх сурвалж: Цаг уур, орчны шинжилгээний газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайланд онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн 3,300.4 сая төгрөг, урсгал зардлын төсвөөс бэлтгэсэн 80.0 сая, балансаас баланс шилжүүлэн авсан 3,688.9 сая төгрөг, хандив тусламжаар 13.6 сая төгрөг, бусад эх үүсвэрээс 6,458.5 сая төгрөгийн хөрөнгө тайлагнаснаас харьяа 3 байгууллагад 812.3 сая төгрөгийн газар эзэмших эрхийг үнэлж, дахин үнэлгээний нэмэгдлээр бүртгэж, нийт 14,353.7 сая төгрөгөөр үндсэн хөрөнгө нэмэгдэж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрээр балансаас балансаас баланст шилжүүлсэн 2,061.3 сая, акталсан 457.3 сая төгрөгөөр хасагдсан байна.

Дорнод аймгийн УЦУОШТ 100.0 сая төгрөг, Увс аймгийн УЦУОШТ 13.9 сая төгрөг, Хөвсгөл аймгийн УЦУОШТ 698.3 сая төгрөг, нийт 812.2 сая төгрөгийн газрыг дахин үнэлгээний нэмэгдэл нь голлон нөлөөлжээ.

### 3.4.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 62.8 сая төгрөг болж, өмнөх оноос 153.1 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт 6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл* /мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өссөн/+/, Буурсан/-/ |
|---|---|---|---|
| Ажилчидтай холбогдсон өглөг | 10,575.7 | 61,958.0 | 51,382.3 |
| Байгууллагад төлөх өглөг | 205,270.3 | 338.1 | (204,932.2) |
| Бараа үйлчилгээний зардлын өглөг | | 276.1 | 276.1 |
| Хувь хүмүүст төлөх өглөг | 0.0 | 192.0 | 192.0 |
| **Нийт дүн** | **215,846.0** | **62,764.2** | **(153,081.8)** |

*Эх сурвалж: Цаг уур, орчны шинжилгээний газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Өглөг дансны үлдэгдэлд Баянхонгор аймгийн УЦУОШТ 9.8 сая төгрөг, Дорнод аймгийн УЦУОШТ 2.5 сая төгрөг, Дундговь аймгийн УЦУОШТ 28.8 сая төгрөг, Төв аймгийн УЦУОШТ 0.6 сая төгрөг, Хөвсгөл аймгийн УЦУОШТ 0.2 сая төгрөг, Улаанбаатар хотын УЦУОШТ 20.9 сая төгрөг, нийт 62.8 сая төгрөг байна.

### 3.4.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 62,002.8 сая төгрөг болж, өмнөх оноос 13,643.3 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 7. Засгийн газрын хувь оролцоо* */ мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт/+/, Бууралт/-/ |
|---|---|---|---|
| Засгийн газрын оруулсан капитал | 26,012,280.1 | 26,787,837.5 | 775,557.4 |
| Хуримтлагдсан үр дүн | 18,010,916.2 | 30,866,809.9 | 12,855,893.7 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 4,336,362.4 | 4,348,180.4 | 11,818.0 |
| **Нийт дүн** | **48,359,558.7** | **62,002,827.8** | **13,643,269.1** |

*Эх сурвалж: Цаг уур, орчны шинжилгээний газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 775.6 сая төгрөгөөр өссөн нь Дорнод аймгийн УЦУОШТ, Хөвсгөл аймгийн УЦУОШТ 2023 оны аудитын зөвлөмжөөр газар үнэлж бүртгэсэн, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг дахин үнэлснээс өмнөх үеийн үр дүн 4,110.9 сая төгрөгөөр, тайлант үеийн үр дүн 8,745.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэнтэй холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2024 оны төсвийн төсөлд урсгал үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 75,321.5 сая төгрөг, үйл ажиллагааны орлогоос 93.3 сая төгрөг, нийт зарлагыг 75,414.8 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн анхны саналыг 9,261.6 сая төгрөгөөр бууруулан 66,153.2 сая төгрөгөөр баталж, төсвийн тодотголоор 10,960.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 77,113.9 сая төгрөгөөр тодотгосон байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн анхны хүргүүлсэн саналаас цалин, хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 5,980.4 сая төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 872.4 сая төгрөг, нийт 6,852.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж, байр ашиглалтын зардлыг 685.3 сая төгрөг, хангамж, бараа материалын зардлыг 507.0 сая төгрөг, нормативд зардлыг 130.3 сая төгрөг, эд хогшил худалдан авах зардлыг 937.0 сая төгрөг, томилолтын зардлыг 273.4 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлыг 2,007.9 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 290.6 сая төгрөг, урсгал шилжүүлгийн зардлыг 322,2 сая төгрөг, нийт 5,153.7 сая төгрөгөөр бууруулж нийт санхүүжилтийг 77,113.9 сая төгрөгөөр баталжээ.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 77,113.9 сая төгрөгийг улсын төсвөөс, 93.3 сая төгрөгийг үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээс гүйцэтгэлээр улсын төсвөөс 75,661.6 сая төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагааны орлого 239.5 сая төгрөгийг бүрдүүлж, зарцуулаагүй 1,366.4 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 75,661.6 сая төгрөг буюу 98.1 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 1,217.1 сая төгрөг, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэгийн зардлын төсвийг 162.1 сая төгрөг, холбооны суваг ашигласны төлбөрийн 50.1 сая төгрөг, ус цаг уурын судалгаа, шинжилгээний зардлыг 12.4 сая төгрөг, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлын зардлыг 10.0 сая төгрөг, харуул хамгаалалтын зардлыг 0.6 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 8* Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган төгрөг/

| Код | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| **71408** | **Цаг уур, орчны шинжилгээ** | **77,113,907.7** | **75,661,610.2** | **1,452,297.5** | **98.1** |
| 80101 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 73,567,998.1 | 72,350,945.5 | 1,217,052.6 | 98.3 |



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 80220 | Холбооны суваг ашигласны хөлс | 360,070.0 | 309,929.2 | 50,140.8 | 86.1 |
| 81701 | Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх | 114,700.0 | 104,700.0 | 10,000.0 | 91.3 |
| 81710 | Ус цаг уурын судалгаа, шинжилгээ | 1,620,112.2 | 1,607,748.8 | 12,363.4 | 99.2 |
| 80802 | Ажил олгогчоос олгох тэтгэмж урамш | 1,447,362.5 | 1,285,216.5 | 162,146.0 | 88.9 |
| 80219 | Харуул, хамгаалалтын зардал | 3,664.9 | 3,070.2 | 594.7 | 83.8 |

*Эх сурвалж: Цаг уур, орчны шинжилгээний газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд Төрийн болон орон нутгийн өмчид бусад этгээдээс 1,714.3 сая төгрөг, Засгийн газрын нөөц сан /Засаг даргын нөөц хөрөнгө/-аас 1,476.1 сая төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 1,164.4 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 887.5 сая төгрөг, нийт 5,242.3 сая төгрөгийн орлогыг эх үүсвэр бүрдүүлж, 581.7 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Үүнээс цалин 1,664.9 сая төгрөг, НДШ-д 207.9 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой зардалд 15.9 сая төгрөг, хангамж бараа материалын зардалд 276.3 сая төгрөг, норматив зардалд 23.2 сая төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 503.9 сая төгрөг, албан томилолтын зардалд 173.9 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 605.9 сая төгрөг, бараа үйлчилгээний зардалд 55.4 сая төгрөг, нийт 3,527.3 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 3.6 Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл

Цаг уур, орчны шинжилгээний газрын 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд улсын төсвийн хөрөнгөөр 2,637.0 сая төгрөгийн худалдан авалтыг зохион байгуулахаар төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 391.9 сая төгрөгийн 4 худалдан авалт, харьцуулалтын болон шууд худалдан авалтын аргаар 1,897.0 сая төгрөгийн 36 худалдан авалтыг зохион байгуулсан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Цаг уур, орчны шинжилгээний газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн ТТЗ, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Санхүү, нийцлийн аудитын газрын ахлах аудитор Г.Мөнхчимэг, аудитор Ч.Мөнхбулган нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Э.Энхбаатар, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Монгол улсын Ерөнхий аудиторын орлогч Я.Самбууням нар тус тус хэрэгжүүлсэн.

Цаг уур, орчны шинжилгээний газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2025 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 07/351 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлыг 2024 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 89,118.4 сая төгрөгөөс 1.0 хувиар тооцож, 891.1 сая төгрөгөөр тогтоосон.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага нь батлагдсан төсвийг хэтрүүлэлгүй, сул орон тоог хадгалах, дотоод цахим сүлжээ ашиглах зэргээр зардлыг хэмнэх арга хэмжээ авч ажилласан байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн аудитын асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус ТТЗ нь шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулах мэдээллийг хуульд заасан хугацаанд бүрэн байршуулсан байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 3,293.3 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, зөвлөмж өгсөн байна.



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл болон худалдан авах ажиллагаа зэрэг нийцлийн аудитын асуудал нь Шилэн дансны тухай болон бусад хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 423.8 сая төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлага, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

*Хүснэгт 9. Өмнөх оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт* /мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Албан шаардлага | 2 | 423,830.2 | 2 | 423,830.2 | 100.0 |
| Зөвлөмж | 1 | - | 1 | - | 100.0 |
| **Нийт дүн** | **3** | **423,830.2** | **3** | **423,830.2** | **100.0** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх асуудал байхгүй гэж үзлээ.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 1,349.4 сая төгрөгийн алдаа[1] илэрснээс аудитын явцад 1,349.4 сая төгрөгийн 28 алдааг залруулсан байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдаагүй нийт 1,341.0 сая төгрөгийн 40 зөрчлөөс 0.6 сая төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1,170.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах 18 албан шаардлага хүргүүлж, 158.8 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 21 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа 26 байгууллагын 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 байгууллага "Хязгаарлалттай", 16 "Өөрчлөлтгүй" дүгнэлт авч, 8 байгууллага түүвэрт хамрагдсан байна.

Залруулаагүй алдаа, зөрчлийн дүн 1,341.0 сая төгрөг нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 891.1 сая төгрөгөөр хэтэрсэн тул "**Хязгаарлалттай**" дүгнэлт өглөө.

### 5.1 Албан шаардлага

1. Өмнөх оноос шилжин ирсэн БНХАУ-аас цаг агаарт зориудаар нөлөөлөх сум, пуужин худалдан авалт 793.3 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т *"Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх"*, 6 дугаар зүйлийн 6.1-д *"Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй"*, 6.4.8-д *"төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх"*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д *"Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ"*, 20 дугаар зүйлийн 20.2.5-д *"Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах"*, 20.2.6-д *"эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах"* гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Төсвийг зохистой удирдаагүй, он дамжсан авлага үүсгэсэн, авлагыг барагдуулаагүй зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

2. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар авлага, цалин урамшуулал илүү олгосон, шууд худалдан авалт хийсэн, анхан шатны баримт бүрдэл хангаж ажиллаагүй зэрэг нийт 500.2 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д *"хариуцлагатай байх"*, 6 дугаар зүйлийн 6.1-д *"Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй"*, 6.6.1-д *"төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө, эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх"*, 14 дүгээр зүйлийн 14.2.3-т *"өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах"*, 15 дугаар зүйлийн 15.4.1-д *"төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8–д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх"* гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Харьяа байгууллагуудын төсөв санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулаагүй зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01 ХЯЗГААРЛАЛТТАЙ

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2025 оны 9 дүгээр сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| № | Байгууллага | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Архангай аймгийн УЦУОШТ | 1 | 6,355.0 | | | 1 | 6,355.0 | 1 | 6,355.0 | | |
| 2 | Баянхонгор УЦУОШТ | 1 | 8,346.4 | | | 1 | 8,346.4 | 1 | 8,346.4 | | |
| 3 | Говь-Алтай аймгийн УЦУОШТ | 2 | 169,620.0 | 1 | 161,553.4 | 1 | 8,066.6 | 2 | 169,620.0 | | |
| 4 | Говь-Сүмбэр аймгийн УЦУОШТ | 6 | 59,305.3 | 1 | 2,400.0 | 5 | 56,905.3 | 6 | 59,305.3 | | |
| 5 | Дорнод УЦУОШТ | 1 | 146,677.9 | | | 1 | 146,677.9 | 1 | 146,677.9 | | |
| 6 | Дорноговь аймгийн УЦУОШТ | 3 | 761,194.1 | | | 3 | 761,194.1 | 3 | 761,194.1 | | |
| 7 | Дундговь аймгийн ЦУОШГ | 3 | 79,228.3 | 2 | 49,700.8 | 1 | 29,527.5 | 3 | 79,228.3 | | |
| 8 | Орхон аймгийн УЦУОШТ | 1 | 332.4 | | | 1 | 332.4 | 1 | 332.4 | | |
| 9 | Өмнөговь аймгийн УЦУОШТ | 4 | 111,396.5 | 2 | 101,447.2 | 2 | 9,949.3 | 4 | 111,396.5 | | |
| 10 | Сэлэнгэ аймгийн УЦУОШТ | 2 | 1,023.7 | | | 2 | 1,023.7 | 2 | 1,023.7 | | |
| 11 | Хөвсгөл аймгийн УЦУОШТ | 2 | 4,663.7 | | | 2 | 4,663.7 | 2 | 4,663.7 | | |
| 12 | Ховд аймгийн УЦУОШТ | 2 | 1,210.0 | | | 2 | 1,210.0 | 2 | 1,210.0 | | |
| | **Дүн** | **28** | **1,349,353.3** | **6** | **315,101.4** | **22** | **1,034,251.9** | **28** | **1,349,353.3** | | |



01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Архангай аймгийн ЦУОШТ | 4 | 7,733.8 | | | 4 | 7,733.8 | | | | |
| Булган аймгийн ЦУОШТ | 2 | 1,484.0 | | | | | 2 | 1,484.0 | | |
| Баянхонгор аймгийн ЦУОШТ | 1 | 9,388.2 | | | | | 1 | 9,388.2 | | |
| Баян-Өлгий аймгийн ЦУОШТ | 1 | 4,134.0 | | | 1 | 4,134.0 | | | | |
| Говь-Алтай аймгийн ЦУОШТ | 4 | 37,129.5 | 1 | 629.5 | 3 | 36,500.0 | | | | |
| Говьсүмбэр аймгийн ЦУОШТ | 1 | 2,139.8 | | | | | 1 | 2,139.8 | | |
| Дорнод аймгийн ЦУОШТ | 6 | 280,845.1 | | | 2 | 273,334.9 | 3 | 7,510.2 | 1 | - |
| Дорноговь аймгийн ЦУОШТ | 1 | 117,495.2 | | | | | 1 | 117,495.2 | | |
| Дундговь аймгийн ЦУОШТ | 2 | 10,654.4 | | | 1 | 1,411.7 | | | 1 | 9,242.7 |
| Орхон аймгийн ЦУОШТ | 2 | 13,621.0 | | | | | 1 | 12,000.0 | 1 | 1,621.0 |
| Сэлэнгэ аймгийн ЦУОШТ | 1 | 8,874.0 | | | 1 | 8,874.0 | | | | |
| Ховд аймгийн ЦУОШТ | 1 | 2,985.3 | | | | | 1 | 2,985.3 | | |
| Хөвсгөл аймгийн ЦУОШТ | 5 | 43,874.9 | | | 1 | 41,684.4 | 4 | 2,190.5 | | |
| Өвөрхангай аймгийн ЦУОШТ | 1 | 3,700.0 | | | 1 | 3,700.0 | | | | |
| Өмнөговь аймгийн ЦУОШТ | 7 | 3,587.9 | | | | | 7 | 3,587.9 | | |
| Цаг уур, орчны шинжилгээний газар | 1 | 793,358.3 | | | 1 | 793,358.3 | | | | |
| **Дүн** | **40** | **1,341,005.4** | **1** | **629.5** | **15** | **1,170,731.1** | **21** | **158,781.1** | **3** | **10,863.7** |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| **Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил** | | | | | | | | | | | | |
| Өмнөговь УЦУОШТ | 1 | 3,293,309.1 | | | 1 | 3,293,309.1 | | | | | | |
| Ховд УЦУОШТ | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| **Дүн** | **3** | **3,293,309.1** | | | **1** | **3,293,309.1** | **2** | **-** | | | | |

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2025 оны 03 сарын 25 өдөр Дугаар 809/А0170074. Улаанбаатар хот
СНАГ-2025/007/НА-СТА-ТТЗ.

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цаг Уур, орчны шинжилгээний газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оноос шилжин ирсэн БНХАУ-аас цаг агаарт зориудаар нөлөөлөх сум, пуужин худалдан авах 793,358,300.00 /долоон зуун ерэн гурван сая гурван зуун тавин найман мянга гурван зуу/ төгрөгийн авлагын үлдэгдлийг барагдуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.1-д *"Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй", 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах"* гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д *"Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө"*, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан *"Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"*-ын 4.2.1.1-т *"нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтлөж, баталгаажуулаагүй"* гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийг зохистой удирдаагүй, он дамжсан авлага үүсгэсэн, авлагыг барагдуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга (Э.Баттулга), Ахлах нягтлан бодогч (Д.Отгонбаяр) нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР Э.ЭНХБААТАР
АХЛАХ АУДИТОР Г.МӨНХЧИМЭГ

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

Z:\Alban Shaardlaga\2025\0325 SNAG-20.Docx

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**АЛБАН ШААРДЛАГА**

2025 оны 03 сарын 25 өдөр Дугаар 810/А0170074. Улаанбаатар хот

СНАГ-2025/007/НА-СТА-ТТ3.

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цаг Уур, орчны шинжилгээний газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар авлага, цалин урамшуулал илүү олгосон, шууд худалдан авалт хийсэн, анхан шатны баримт бүрдэл хангаж ажиллаагүй зэрэг нийт 500,184,300.00 төгрөгийн зөрчил илэрсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д *"хариуцлагатай байх"*, 6 дугаар зүйлийн 6.1-д *"Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй"*, 6.6.1-д *"төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө, эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх"*, 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 15 дугаар зүйлийн 15.4.1-д *"төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8–д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх"* гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д *"Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө"*, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "*Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам*"-ын 4.2.1.1-т "*нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй*" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Харьяа байгууллагуудын төсөв санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга (Э.Баттулга), Ахлах нягтлан бодогч (Д.Отгонбаяр) нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР Э.ЭНХБААТАР

АХЛАХ АУДИТОР Г.МӨНХЧИМЭГ

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

Утас: +976 51 261585
Факс: +976 11 323266, 324653

Цахим шуудан: info@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

Хаяг: Засгийн газрын IV байр